

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН “ОЮУТОЛГОЙ БҮЛЭГ ОРДЫН АШИГЛАЛТАД
МОНГОЛ УЛСЫН ЭРХ АШГИЙГ ХАНГУУЛАХ, ХҮРТЭХ ӨГӨӨЖИЙГ
НЭМЭГДҮҮЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ БАРИМТ БИЧИГ, ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ” ҮҮРЭГ БҮХИЙ ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2025 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр, Мягмар гараг
Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-3

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 4-18

1.Түр хорооны тогтоолын төсөл /Нотлох баримт гаргуулах тухай/ 4-5

2.Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 73 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн явцын мэдээлэл болон 5-18

3.Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 67 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн явцын мэдээллийг сонсох 5-18

Монгол Улсын Их Хурлын “Оюутолгой бүлэг ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах, хүртэх өгөөжийг нэмэгдүүлэхтэй холбоотой баримт бичиг, үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх” үүрэг бүхий Хянан шалгах түр хорооны 2025 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр /Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл

Хянан шалгах түр хорооны дарга О.Батнайрамдал ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 11 гишүүнээс 6 гишүүн хүрэлцэн ирж, 54.5 хувийн ирцтэйгээр нээлттэй хуралдаан 15 цаг 14 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

*Томилолттой: Ш.Бямбасүрэн, П.Ганзориг;
Чөлөөтэй: Д.Пүрэвдаваа.*

Түр хорооны дарга О.Батнайрамдал “Хянан шалгагч томилж, ажлын даалгавар батлах тухай” болон “Шинжээч томилох тухай” Түр хорооны тогтоолын төслийг хаалттай горимоор хэлэлцэх тухай мэдэгдэж, хуралдаан хаалттай горимд шилжив./15:16/

Хаалттай хуралдаан 15 цаг 16 минутаас 15 цаг 40 минутад хуралдаж, 15 цаг 40 минутаас нээлттэй горимд шилжив.

Нэг.Түр хорооны тогтоолын төсөл /Нотлох баримт гаргуулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, Хяналт шалгалтын газрын дарга Ч.Онончимэг, референт Д.Мөнхтуяа, ахлах мэргэжилтэн С.Сэргэлэн нар байлцав.

Түр хорооны дарга О.Батнайрамдал тогтоолын төслийг Улсын Их Хурлын гишүүдэд тараасан талаар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

О.Батнайрамдал: “Нотлох баримт гаргуулах тухай” Түр хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	6
Татгалзсан:	1
Бүгд:	7

85.7 хувийн саналаар Түр хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 15 цаг 42 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 73 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн явцын мэдээлэл болон

Гурав.Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 67 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн явцын мэдээллийг сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Эрдэс баялгийн бодлогын газрын дарга Г.Намчинсүрэн, Татварын ерөнхий газрын Том татвар төлөгчийн газрын Эрдэс баялгийн татварын хэлтсийн дарга С.Мөнхбаатар, мөн газрын Үнэ шилжилтийн хэлтсийн дарга Ц.Одончимэг, Ашигт малтмалын газрын тосны газрын Уул уурхайн хэлтсийн дарга Т.Зууннаст, Үндэсний геологийн албаны дарга Н.Мөнхбилэг, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Наранцогт, мөн компанийн Чанар, бүтээмж хариуцсан менежер Д.Ядамжав, Төслийн судалгаа, үнэлгээний газрын дарга Д.Батмөнх, мөн хэлтсийн менежер Ү.Чулуунбаатар, “Оюу толгой” ХХК-ийн ТУЗ-ийн гишүүн Н.Цэрэнбат, Э.Мэндтүвшин, Д.Цолмон, “Эрдэнэс Оюутолгой” ХХК-ийн гүйцэтгэх захирал Э.Ганхүү, мөн компанийн Нэгдсэн стратеги төлөвлөлтийн газрын Ерөнхий менежер Б.Батбаатар, Уул уурхай, технологийн хэлтсийн менежер Л.Өнөрбаатар, Санхүү, төлөвлөлт, шинжилгээний хэлтсийн менежер Б.Баяр-Өлзий, Хуулийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Ц.Мөнх-Оюунбаатар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, Хяналт шалгалтын газрын дарга Ч.Онончимэг, референт Д.Мөнхтуяа, ахлах мэргэжилтэн С.Сэргэлэн нар байлцав.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 73 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн болон Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 67 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн явцын талаарх мэдээллийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Эрдэс баялгийн бодлогын газрын дарга Г.Намчинсүрэн танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, С.Зулпхар, О.Батнайрамдал, Б.Жаргалан, Э.Болормаа нарын тавьсан асуултад Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Эрдэс баялгийн бодлогын газрын дарга Г.Намчинсүрэн, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Наранцогт, “Эрдэнэс Оюутолгой” ХХК-ийн гүйцэтгэх захирал Э.Ганхүү нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан, Э.Болормаа, О.Батнайрамдал нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 73 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн явцын мэдээлэл болон Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 67 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн

явцын талаарх Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Эрдэс баялгийн бодлогын газрын дарга Г.Намчинсүрэнгийн хийсэн мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 16 цаг 23 минутад хэлэлцэж дуусав.

Түр хорооны дарга О.Батнайрамдал “Оюу толгой” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, гүйцэтгэх удирдлагын багийн танилцуулга, мэдээллийг сонсох асуудлыг ажлын хэсэг байхгүй тул хойшлуулав./16:25/

Нээлттэй хуралдаан 47 минут үргэлжилж, 11 гишүүнээс 8 гишүүн хүрэлцэн ирж, 72.8 хувийн ирцтэйгээр 16 цаг 25 минутад өндөрлөв.

Түр хорооны нээлттэй хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ХЯНАН ШАЛГАХ ТҮР
ХОРООНЫ ДАРГА

О.БАТНАЙРАМДАЛ

Тэмдэглэл хөтөлсөн:

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим
15 цаг 14 минут.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН “ОЮУТОЛГОЙ БҮЛЭГ ОРДЫН АШИГЛАЛТАД МОНГОЛ УЛСЫН ЭРХ АШГИЙГ ХАНГУУЛАХ, ХҮРТЭХ ӨГӨӨЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ БАРИМТ БИЧИГ, ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ” ҮҮРЭГ БҮХИЙ ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

О.Батнайрамдал: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Оюутолгой бүлэг ордын ашиглалтын асуудлаарх Хянан шалгах түр хорооны гишүүдийн ирц бүрдсэн тул 2025 оны 11 дүгээр сарын 4-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Хуралдаанд хүрэлцэн ирсэн гишүүдийн ирцийг та бүхэнд танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Мягмарсүрэнгийн Бадамсүрэн, Улсын Их Хурлын гишүүн Баярмагнайн Баярбаатар, Улсын Их Хурлын гишүүн Бат-Өлзийн Бат-Эрдэнэ, Улсын Их Хурлын гишүүн Энхбатын Болормаа, Улсын Их Хурлын гишүүн Сархадын Зулпхар, Улсын Их Хурлын гишүүн Отгоншарын Батнайрамдал гэсэн 54.5 хувийн ирцтэйгээр хуралдаан эхэлж байна.

Өнөөдрийн хуралдаанаар дараах асуудлыг хэлэлцэнэ. Үүнд:

Тов дээр “Бусад” гэж орсон байгаа. “Хянан шалгагч томилж, ажлын даалгавар батлах тухай” тогтоолын төсөл байгаа. “Шинжээч томилох тухай” тогтоолын төсөл. Энэ 2 маань томилгоотой холбоотой учраас богинохон хаалттай явна. Мөн “Нотлох баримт гаргуулах тухай” Хянан шалгах түр хорооны тогтоолын төсөл байгаа. Мөн Монгол Улсын Ерөнхий сайдын 73 болон 67 дугаар захирамжаар байгуулагдсан 2 ажлын хэсгийн нэгтгэсэн явц мэдээллийг сонсоод эцэст нь товд орсноор “Оюутолгой” компанийн удирдлагын багийн танилцуулга, мэдээлэл сонсох гэсэн товтой байна.

Хэлэлцэх асуудлын талаар өөр саналтай гишүүн байна уу?

Байхгүй байна.

Хэлэлцэх асуудалдаа оръё. Эхний хэлэлцэх асуудал маань хянан шалгагч томилж, томилох асуудалтай холбоотой учраас хаалттай явах ёстой. Хаалттай горимд. Шилжүүлнэ үү.

О.Батнайрамдал: Нээлттэй горим руу шилжлээ. Дараагийн асуудлаа. Харин тийм.

Та бүхэнд Монгол Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооны нотлох баримт цуглуулахтай холбоотой тогтоолын төслийг та бүхэнд тараасан байгаа.

Тогтоолын тийм шүү дээ. Тогтоолын төсөлтэй холбоотой асуулт асууж, үг хэлэх гишүүд байна уу? Нэрсээ өгнө үү.

Байхгүй байна.

Тогтоолын төслийг та бүхэнд тараасан байна. 4 хуудас нотлох баримт цуглуулах хүрээтэй холбоотой.

Тэгэхээр тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад гишүүд бэлдэнэ үү. Тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

Нийт гишүүдийн 85.7 хувь дэмжиж, “Нотлох баримт гаргуулах” тогтоолын төсөл батлагдлаа.

15.42 цаг

Дараагийн асуудалдаа оръё. Засгийн газарт Ерөнхий сайдын захирамжаар байгуулагдсан 75, 83 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн явцтай танилцана.

Ажлын хэсгийн гишүүдийг хуралдаанд оруулъя. Ажлын хэсгийн гишүүдийг оруулъя.

Оюутолгой бүлэг ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах, хүртэх өгөөжийг нэмэгдүүлэхтэй холбоотой баримт бичиг, үйл ажиллагаанд хянан шалгалтыг хянан шалгах түр хорооны хуралдаанд Ерөнхий сайдын захирамжаар Ерөнхий сайдын 73 болон 67 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хамтатгасан ажлын хэсэг та бүхэндээ танилцуулж байна.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Дамдинням, Татварын ерөнхий газрын Том татвар төлөгчийн газрын Эрдэс баялгийн татварын хэлтсийн дарга Мөнхбаатар, Татварын ерөнхий газрын Үнэ шинэчлэлтийн хэлтсийн дарга Одончимэг, Ашигт малтмал, газрын тосны газрын Уул уурхайн хэлтсийн дарга Зууннаст, Үндэсний геологийн албаны дарга Мөнхбилэг, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Эрдэс баялгийн бодлогын газрын дарга Намчинсүрэн, “Эрдэнэс Монгол” компанийн захирал, гүйцэтгэх захирал Наранцогт, “Эрдэнэс Монгол” компанийн Чанар, бүтээмж хариуцсан менежер Ядамжав, “Эрдэнэс Монгол” компанийн Төслийн судалгаа, үнэлгээний газрын дарга Батмөнх, “Эрдэнэс Монгол” компанийн Төслийн судалгаа, үнэлгээний газрын Төслийн үнэлгээний хэлтсийн менежер Чулуунбаатар, “Оюутолгой” компанийн Монголын талын ТУЗ-ийн гишүүн Цэрэнбат, Мэндтүвшин, Цолмон, “Эрдэнэс Оюутолгой” компанийн гүйцэтгэх захирал Ганхүү, “Эрдэнэс Оюутолгой” компанийн Уул уурхай, технологийн хэлтсийн менежер Өнөрбаатар, “Эрдэнэс Оюутолгой” компанийн Санхүү, төлөвлөлтийн шинжилгээний хэлтсийн менежер Баяр-Өлзий, мөн “Эрдэнэс Оюутолгой” компанийн Хуулийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Мөнхбаатар гэсэн ажлын хэсэг хүрэлцэн ирсэн байна. Дамдин сайд хаачихсан ирж байна уу? Одоо орж ирж байна уу тээ?

Бид нар ямар ч байсан Хянан шалгах түр хороо байгуулагдсанаасаа хойш зээл, ялангуяа Оюутолгойн хувь нийлүүлэгчийн зээлийн хүүг бууруулахтай холбоотой цаг хугацаа тулсан асуудал байсан учраас Хянан шалгах түр хороо бараг

Байнгын хорооны хэмжээнд хуралдаж, хамгийн гол нь бидний хүлээж байсан зүйл хэлэлцээрт Монгол Улсын Засгийн газар хөрөнгө оруулагч талтай хэлэлцээрт орох байсан. Ямар ч байсан бидний авсан мэдээллээр Ерөнхий сайдын 67, 68, 73 гэж байна тээ? Энэ дээр байгуулагдсан захирамжаар байгуулагдсан ажлын хэсгүүд “Рио Тинто” компанийн хооронд хэлэлцээрт түрүүчийн долоо хоногоос албан ёсоор орсон гэж үзэж байгаа юм.

Тэгэхээр яах вэ бидний хүсээд байсан зүйл ерөөсөө хэлэлцээртээ албан ёсоор ороод энэ ажил цаг хугацаандаа үргэлжлэх л байсан. Тэгээд 2 тал ямар ч байсан албан ёсоор ингээд хэлэлцээрт орж байгаа. Орсонд ер нь талархалтай хандаж байгаа. Яагаад гэвэл цаг хугацаа үнэхээр тулчихсан зээлийн тэр хувь нийлүүлэгчийн гэрээн дээр энэ чинь 7 жил тутам ганц олдог боломж байсан учраас энэ дээр цаг хугацаандаа хэлэлцээрт орохыг л бид нар Хянан шалгаж энэ түр хорооны гишүүд энд бүгдээрээ сууж байна. Бид нар хүссэн юм. Тэгэхээр ингээд нэгэнт хэлэлцээрт ороод явж байгаа бол бид нар ч яах вэ ер нь цаашдаа Засгийн газар ингээд хэлэлцээр үргэлжилж байхад ингээд долоо хоног тутам бид нар та нарыг заавал дуудах албагүй ээ. Шаардлагагүй ээ. Хамгийн гол нь бид нар та нарыг долоо хоног тутамд дуудаад байсан үндсэн шалтгаан Ерөнхий сайдын захирамж гарчихсан байна. Тэгэхээр энэ ажлын хэсгүүд хуралдаад хэлэлцээртээ 2 талаасаа орооч л гэж гэсэн.

Тэгэхээр Дамдинням сайд ирж байгаа гэж ойлгосон тийм үү? Дамдинням сайд хэлэлцээрийг ахалж орж байгаа гэж ойлгож байгаа. Сая Ерөнхий сайд дээр танилцуулга хийх ёстой гээд түр гарчихсан тэгээд хүрч ирж амжих нь уу? Ерөнхий сайд дээр танилцуулга хийх гэж байгаад тэр танилцуулгадаа та түр орж бай гээд хэлчихсэн юм би бас. Дуусаагүй байх шиг байна.

Тэгвэл хэлэлцээрийн, бид нарт авсан мэдээллээр хэлэлцээрийн протокол гарсан гэж ойлгож байгаа. Тэгэхээр хэлэлцээртэй холбоотой та бүхэн гишүүдийн асуултад ерөнхийдөө хариулаад л. Бид нар бол хэлэлцээрт орж байгаа доторх тактикийн зүйл огт асуухгүй ээ. Тэр талаар та бүхэн өнөөдрийн нээлттэй хуралдаанд ярих шаардлагагүй.

Тэгэхээрээ бидний Хянан шалгах түр хороон дээр Ерөнхий сайдын захирамжаар байгуулагдсан энэ ажлын хэсгийг дуудаж байгаа үндсэн шалтгаан бол хэлэлцээртээ яаралтай ороод үйл ажиллагаа цэгцрээсэй л гэж хүссэн. Тэгэхээр нээлттэй байгаа мэдээллийн хүрээндээ гишүүдийн асуултад та бүхэн тэгвэл Дамдинням сайдыг хүртэл хариулаад явж байа тээ, гишүүд ээ тэгэх үү? Тэгье. Тэгэхээр ямар ч байсан эхлээд танилцуулгаа хэн хийх вэ Дамдинням сайдын оронд? Ажлын хэсгийн танилцуулгыг хэдэн номерын микрофон? 6 номерын микрофон. Аж үйлдвэр, эрдэс баялгийн газрын дарга Намчинсүрэн.

Г.Намчинсүрэн: Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооны дарга, гишүүдэд өдрийн мэнд хүргэе. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам Уул уурхайн бодлогын газрын Намчинсүрэн.

Оюутолгой төслийн тулгамдаж буй асуудлыг шийдвэр зорилгоор Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 67, 68, 73 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгүүд нэгдсэн төлөвлөгөө баталж уялдаа холбоотой нэгдсэн зохион байгуулалтын доор хамтран ажиллаж байна. Монгол Улсын Засгийн газрын 2000, өнгөрсөн Засгийн газрын хуралдаанаас ажлын хэсгүүдийн үйл ажиллагаанд

баримтлах удирдамжийн дагуу баталж өгсөн удирдамжийн дагуу 2025 оны 10 дугаар сарын 30, 31-ний өдрүүдэд эдгээр ажлын хэсэг болон “Рио Тинто” групп хооронд албан ёсоор дараах тодорхой асуудлуудаар урьдчилан тохиролцож хэлэлцээг эхлүүлсэн. Үүнд:

Оюутолгой төслийн хувь нийлүүлэгчдийн зээлийн хүүгийн зохистой байдлыг хянан үзэх хэлэлцээг албан ёсоор эхлүүлсэнд тооцож, талууд 2026 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн дотор шийдвэрлэхийг эрмэлзэнэ. Хэрэв талууд дурдсан хугацааны дотор зөвшилцөлд хүрээгүй хэлэлцээ хийх хугацааг сунгахаар тохиролцсон.

Хоёрдугаарт олон улсын зах зээлийн стандартын дагуу хувь нийлүүлэгчдийн зээлийн хүүгийн хувийг тогтоох бөгөөд хувь нийлүүлэгчдийн зээлийн хүүтэй холбоотойгоор талуудын харилцан зөвшилцсөн бусад нөхцөлүүдийг хэлэлцэх ба шийдлийг авч үзнэ.

Гуравдугаарт, менежментийн үйлчилгээний төлбөрийг талууд олон улсын жишигт нийцсэн, талуудын хувьд шударга, хүлээн зөвшөөрөхүйц шийдлийг олохоор ажиллана. Талууд хэлэлцээний явцад эрх бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг өөрчлөхгүй байхыг эрмэлзэнэ.

Тавдугаарт, талууд протоколд туссан асуудлаар хэлэлцээ хийж, шийдвэрлэх бүрэн эрхтэй байхаар бол харилцан тохиролцсон урьдчилсан, үндсэн протоколоо бол үйлдсэн.

Хоёрдугаарт, Оюутолгой хэлэлцээрийн Монголын талын нэгдсэн багийг ахалж 2 өдөр “Рио Тинто” төлөөлөгчтэй хэлэлцээ хийж багагүй үр дүнтэйгээр энэ удаагийн хэлэлцээг өндөрлүүлсэн. Бид бол Засгийн газраас баталж өгсөн удирдамжийн дагуу хэлэлцээрт орж нэн түрүүнд Оюутолгой төслийн хувь нийлүүлсэн зээлийн хүүг хэлэлцэх ээлжит 7 жилийн хугацааг дуусаж байгаа гэх түгжээг тайлж, тус хугацааг үл харгалзан хэлэлцээрийг үргэлжлүүлэхээр, үргэлжлүүлж үр дүнд нь хүрэхээр” Рио Тинто” талтай тохиролцож чадлаа.

Хоёрдугаарт, Оюутолгой төслийн хувь нийлүүлсэн зээлийн хүүг бууруулахаар тохиролцож чадлаа. Тус асуудлаар бол хэлэлцээрийг үргэлжлүүлж хоёр тал 11 дүгээр сардаа багтан 2 талаас тавьж буй бусад нөхцөлүүдийн талаарх шаардлагатай мэдээлэл, саналуудыг нягтлан үзэж шийдвэрлэхээр тохиролцсон.

Оюутолгой төслийн менежментийн үйлчилгээний төлбөрийг бол бодитой бууруулах, засаглалын чанарыг сайжруулах чиглэлээр манайд тавьсан саналыг айл бол эхний удаа хүлээж аваагүй. Энэ чиглэлээр ахин судлах яриа хэлцлийг бол хийж, хийсэн байгаа. Айлын талаас бол энэ чиглэлээр дахин хэлэлцээрт оръё гэдэг мэдэгдлээ бол Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдад ирүүлсэн.

Хэлэлцээний үеэр ажлын хэсгийн зүгээс “Онтрэ”-гийн эзэмшиж байгаа тусгай зөвшөөрөлтэй холбоотой байр суурийг бол тодорхой илэрхийлээд илэрхийлчихсэн. “Онтрэ”-гийн бол удирдлагыг бол хэлэлцээ хийх урилгыг бол Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдаас хүргүүлээд байгаа.

Анхаарал тавьсанд баярлалаа.

О.Батнайрамдал: Танилцуулгатай холбоотойгоор асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү.

Зулпхар гишүүнээр тасалъя. Бат-Эрдэнэ гишүүний микрофоныг өгье.

Б.Бат-Эрдэнэ: Хэлэлцээр амжилттай л явагдаж байгаа юм шиг байна. Нөгөө зээлийн хүүгийн хэмжээг эцэслэн тогтоогүй байгаа гэж ойлголоо. Түгжээг тайлсан гэдэг нь 7 жил тутам 1 гэдгийг маш ойлгомжтойгоор жил тутам хийгээд явах боломжтой ч байж болно гэдэг агуулгаар ойлгож болох уу? Тэрийг яг юу гэж ойлгох билээ? Түгжээг тайлна гэдэг нь яг тайлбарлаад өг өө тэрийг яг тодорхойгоор. Баярлалаа.

О.Батнайрамдал: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. 6 номерын микрофон тодорхой хариулъя.

Г.Намчинсүрэн: Гишүүний, Наранцогт захирал хариулсан нь зөв юм байна. Ажлын хэсгийн дэд даргаар байгаа.

О.Батнайрамдал: 9 номерын микрофон.

С.Наранцогт: Наранцогт “Эрдэнэс Монгол”. Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Энэ хугацааны хувьд бид нар 7 жил биш энэ хэлэлцэх асуудал дотор энэ хэдэн жил тутам гэдэг саналаа тавьчихсан байгаа. Бид нар нөгөө Өрийн удирдлагын хуультай холбоотойгоор. Энэ саяын хугацаа хамаарахгүй гэдэг нь энэ удаагийн хэлэлцээрийг бид нар тодорхой үр дүн гартлаа 2 тал ойлголцтолоо энэ 26 оны 1 сарын 31 хүртэл үр дүнд хүрэхийг эрмэлзэнэ. Эрмэлзээд үр дүнд хүргээгүй юм гэсэн тохиолдолд хугацаа хамаарахгүйгээр энэ хэлэлцээрээ үргэлжлүүлж үр дүн гаргана гэсэн үг. Тэр хэлэлцээрийн хэлэлцэх асуудал дотор нь энэ 7 жил гэсэн асуудлыг өөрчилнө өө гэдэг санал тавигдчихсан явж байгаа.

О.Батнайрамдал: Бат-Эрдэнэ гишүүн нэмж тодруулъя.

Б.Бат-Эрдэнэ: Тэгвэл Дамдинням сайдын яриад байгаа буруу яваад байгаа юм байна. Та бүхэн энэ удаагийн хэлэлцээрийг 26 оны 12 сарын 31 өдрийг хүртэл хэдэн ч удаа дотор нь өөрчлөлт хийж тодорхой хэлэлцэх асуудал хөндөж болно. Нөгөө 7 жил тутам 1 удаа гэдэг бол эцэслэгдэн шийдвэрлэгдээгүй энийг бол хугацааг дахин ярилцаж байгаа гэдэг хэлбэр гэж ойлголоо. Зөв үү? Тэгвэл нийгэмд, бид нар ч гэсэн тийм мэдээлэл авсан шал буруу ойлголттой явж байгаа юм байна шүү дээ. 7 жил тутам 1 гэдэг ойлголт бол яг одоогоор эцэслэгдээгүй л байгаа юм байна шүү дээ тээ? Тийм ойлголт юм байна даа.

О.Батнайрамдал: Бат-Эрдэнэ гишүүний асуултад ойлгомжтой нэмж хариулт.

Б.Бат-Эрдэнэ: Албан ёсоор протоколд тэмдэглэж байгаа юм чинь.

О.Батнайрамдал: Нэмж хариулт авах уу та?

Б.Бат-Эрдэнэ: Авчихъя.

О.Батнайрамдал: Тэгье Бат-Эрдэнэ гишүүний асуултад нэмж тодруулахад хэн хариулах вэ? 9 номер микрофон.

С.Наранцогт: Тийм, саяынх би Дамдинням сайд яг яаж тайлбарлаад яаж ойлгогдсоныг мэдэхгүй байна. Яг энэ протоколын тохирсон утгыг энэ удаагийн хэлэлцээрийг бид нар хугацаа харгалзахгүй хэлэлцээрийн үр дүн гаргана. Хэлэлцэх асуудал дотор энэ зээл, зээлийн хүүгийн энэ хэмжээ, тооцох аргачлал, дээр нь нэмээд энэ нөгөө таны асуусан хэдэн жил тутам энэ хүүгээ эргэж харах юм бэ гэдэг энэ асуудлууд хэлэлцэх асуудал дотор нь явж байгаа юм.

О.Батнайрамдал: Зулпхар гишүүн асуултаа асууя.

С.Зулпхар: Түр хорооны түр хорооны дарга, гишүүд, ажлын хэсгийнхэнд энэ өдрийн мэндийг дэвшүүлье. Монгол Улсын Засгийн газар үндэстэн дамнасан корпорацтай томоохон хэлэлцээрийг өнгөрсөн долоо хоногт хийлээ. Бас эхний үр дүнгүүд гарч байгаад бас сайшаалтай байна, бас баяртай байна. Гэхдээ мэдээж хэрэг цаашдаа бол энэ хэлэлцээр үргэлжлэх юм байна. Хэлэлцээрийг бол цаашдаа бид ямар ч хугацаанд яаж хийж болох энэ үүд хаалга нээж байгаа нь бас сайшаалтай. Ер нь тийм ч байх ёстой. Хэлэлцээр гэдэг бол тодорхой нөхцөлд талууд ашиг сонирхлоо эрх тэгш байлгах үүднээс яригддаг зүйл учраас энийг бид ер нь Засгийн газрын түвшинд Улсын Их Хурал, Улсын Их Хурал дахь түр хорооны түвшинд ярьсаар байгаад ингээд үр дүн гарч байгаад талархалтай байна. Манай гишүүд бүгд энд оролцож байгаад нь.

Би хэдэн асуулт байна. Сая бол яах вэ зээлийн хүүгээ буулгах дээр бол үндсэндээ бол буулгая гэдгээ тохирсон. Гэхдээ хэд буулгахаа бол тохироогүй гэж ойлголоо.

Хоёрт, 2 зүйл байгаа үлдсэн. Нэг нь тэр менежментийн зардлыг буулгах асуудал. Нөгөөх нь засаглалын асуудал байгаа шүү дээ. Манай талын засаглал дахь оролцооны асуудлыг бид энэ илүү байлгах, тэгш байлгах чиглэлээр л ажиллах ёстой гээд. Энэ дээр энэ айлын тал манай тавьж байгаа саналыг хэрхэн хүлээж авсан бэ гэдэг ийм асуултыг асуумаар байна. Та бүхэн энэ дээр 2, 3 хувилбар бэлдсэн гэсэн шүү дээ? Яах вэ тэр хувилбараа бидэнд ярих нь албагүй.

Гэхдээ энэ нь бол хандлага нь ямар байгаа юм бэ гэдгийг мэдмээр байна нөгөө талын. Тэрнээс гадна бас нэг зүйлийг бас тодруулж асуумаар байна. Бид ингээд өнгөрсөн ингээд Түр хорооны хуралдаанууд дээр ийм мэдээлэл авсан байхгүй юу. Бид Оюутолгой дээр ингээд аудит оруулах гэсэн чинь аудит хийх зардал нь байхгүй гэсэн ийм зүйл та бүхэн хариулсан. Би энийг сайн санаж байна. Надад 3 ч хүн хариулсан. Тэгсэн сая 20 сая долларын асуудал яригдсан. 20 сая доллар бол Оюутолгойд хяналт хийх, хяналт тавих зорилгоор Монголын талд Оюутолгойгоос өгсөн мөнгө юм байна гэдэг ийм мэдээллийг авчхаад байж байна одоо. Тэгэхлээр тэр үед та бүхний өгсөн хариулт ямар учиртай байсан юм? Одоо энд тэр 20 сая доллар дотор чинь бас тодорхой мөнгө үлдсэн л байлгүй. Аудит хийлгэх мөнгө чинь байгаа юу гэдэг ийм асуулт байна. Баярлалаа.

О.Батнайрамдал: Зулпхар гишүүний асуултад тодорхой хариулъя. Хэн хариулах вэ? Наранцогт захирлаас эхэлье, 9 номерын микрофон. Дараа нь Ганхүү захирал бэлдэж байгаарай.

С.Наранцогт: Зулпхар гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр менежмент, засаглалыг сайжруулах асуудал мөн хийгдэж байгаа. Ажлын 2 хэсэг гэж үзээд яг

зээлийн нэгдсэн ажлын хэсэг байгаа боловч дэд ажлын хэсэгт, нэг ажлын хэсэг нь яг зээлийн хүүг бууруулах дээр Жавхлан сайдаар ахлуулаад төвлөрч ажиллаж байгаа. Менежментийн төлбөр болоод энэ засаглалыг сайжруулах ажлын хэсгийг Дамдинням сайд ахлаад ингээд ажиллаж байгаа .

Менежмент болоод засаглал дээр бол Монгол талаас, Засгийн газраас бас удирдамж гарсан. Тэгэхдээ яах вэ энэ хэлэлцээр дуустал энэ нууцын зэрэгтэй хэлэлцээрийн тактик учраас бид нарын яг баримтлах тэр удирдамж гараад тэрний дагуу хэлэлцээр хийгдэж байгаа. Манай талаас 9 төрлийн асуудал тавьсан. Нэлээн хатуу байр суурь тавьсан учраас зарим асуудлуудыг нь яг энэ хэлэлцээрийн үед хэлэлцэх бололцоогүй байна гэдэг нөгөө талаас тавиад өөрөөр хэлбэл нөгөө тал хэлэлцээрт хийхээр ирсэн улсуудын бас мандатын хүрээнд байсан эсэхийг бид мэдэхгүй байна. Иймэрхүү ийм нөхцөл байдал үүссэн учраас яг эндээ энэ асуудал дээр хэлэлцээрийн протокол яг тухайн өдөр хийгдэх боломжгүй байна гэдэг байдалтай байсан.

Харин өнөөдрийн байдлаар үргэлжлээд 2 талын уулзалтууд бас хийгдээд Дамдинням сайдад нөгөө талаас энэ хэлэлцээрийн протоколыг яг бид нарын тавьсан хүрээнд авч үзэж, яг олон улсын болоод зах зээлийн зарчимд нийцүүлэн харилцан хэлэлцээд хэлцэл хийе гэдэг ийм албан бичиг ирүүлсэн байгаа. Тэгэхээр протоколыг хийе гэвэл бас хийхэд бэлэн байна гэсэн ийм мэдэгдлийг ирүүлсэн гэдгийг танд хэлье.

О.Батнайрамдал: Нэмэлт 4 номер.

С.Наранцогт: 2 дахь асуултыг Ганхүү захирал хариулчих байх. Нөгөө 20 сая доллартой холбоотой

О.Батнайрамдал Эрдэнэс Оюутолгойн гүйцэтгэх захирал Ганхүү. 4 номерын микрофон.

Э.Ганхүү: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. “Эрдэнэс Оюутолгой” компани 21 оноос эхлээд Оюутолгой төслөөс, Оюутолгой төслийн Оюутолгой ТУЗ-ийн 274 дүгээр тогтоолоор жилдээ 5 сая буюу 4 жилийн хугацаанд 20 сая доллар авч далд уурхайн бүтээн байгуулалтад хяналт тавих үндэслэлтэй санхүүжилт авч явсан байсан. Өнөөдрийн байдлаар нийт 20 саяынхаа 18.2 сая долларыг авсан байгаа. Энэ зардал бол зөвлөх үйлчилгээ авсан төсөв буюу хуулийн мөн олон улсын багийн гэсэн Засгийн газрын хуралдаанд оруулаад зөвлөх үйлчилгээ авсан байгаа. Мөн дээр нь “Эрдэнэс Оюутолгой” компанийн үйл ажиллагаа, засаглалыг сайжруулах гэсэн үндсэн эх үүсвэртэй байсан. Үүний дагуу зарцуулаад зардлаа гаргаад явсан.

Одоогийн байдлаар зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулсан ажилтнууд холбогдох хуулийн дагуу Тагнуулын ерөнхий газарт нууцын гэрээнээс гаргаж өгсөн үү гэсэн бичгийг 10 сарын 3-нд хүргүүлсэн байгаа. Энэ хүргүүлсэн учир шалтгаан нь гэх юм бол 9 сарын 23-нд Засгийн газрын хуралдаанаар “Оюутолгой”, “Эрдэнэс Оюутолгой” компанид хийгдсэн байгаа зөвлөх үйлчилгээний гаднын зөвлөх үйлчилгээний гэрээнүүдийг ил болгоно гэсэн шийдвэр гарсан. Шийдвэр гарсны дагуу холбогдох ажлын хэсэг байгуулаад 10 сарын 3-нд Тагнуулын ерөнхий газар жагсаалтаар нь хүргүүлсэн байгаа. Өнөөдрийн байдлаар “Эрдэнэс Оюутолгой” компанид албан ёсны хариу нь ирээгүй байгаа учраас тухайн компани дээр нууц

дээрээ байгаа. Мөн цагдаагийн газраас холбогдох шийдвэрийн дагуу бүх нууцад байсан материалыг өнгөрсөн долоо хоногт аваад явсан байгаа. Одоогийн байдлаар эцсийн тайлан, үр дүн бид нарт гарсан тийм дүгнэлт ирээгүй байгаа.

Далд уурхайн зардлын хувьд гэх юм бол ерөнхийдөө “Рио Тинто” компани зөвхөн санхүүжилт талдаа “Эрнст энд Ян” компаниар дүгнэлт хийлгээд гаргасан байгаа. Монголын тал болохоор зардал талдаа санхүүжилт талдаа биш аль зардал талдаа байх, аудит хийлгэх ёстой гэсэн шаардлагыг тавьсан. Үүний дагуу Монголын тал тэгвэл албан ёсны ажлын даалгавраа боловсруулж ир гэсэн байгаа. 103 дугаар тогтоолоор өгсөн чиг үүргийн дагуу ажлын хэсэг зардал талд нь аудит хийлгэ гэсэн ажлын даалгавраа хүргүүлсэн. “Рио Тинто” компани одоогоор аудит хийлгэсэн дүгнэлтээ ирүүлээгүй байгаа.

О.Батнайрамдал: Зулпхар гишүүн нэмж тодруулъя.

С.Зулпхар: Баярлалаа. Ямар ч байсан тэр менежментийн зардлыг бууруулахтай холбоотой, засаглалтай холбоотой бол манай талын санал их тийм хатуу байр суурь байгаа юм байна. Тэгэхдээ манай талын эрх ашгийг хангах чиглэлд айлын тал энэ саналыг ер нь эргээд ярина гэдгээ бол илэрхийлчихсэн юм байна. Энэ бас сайшаалтай байна. Хэлэлцээрийн бас үр дүн гэж ойлгож байна. Би яах вэ Ганхүү захирлаас тодруулах гээд байгаа нь өмнөх уулзалтууд дээр яг ийм л юм асуугаад би тийм л ойлголт авчихсан юм. Бичээд авчихсан л байна лээ л дээ. Бид гүний уурхай дээр аудит хийлгэх гэсэн чинь санхүүгийн гэдэг юм уу, эс үгүй бол тэр гүйцэтгэлийн тэгсэн тэрэнтэй холбоотой зардал нь хаанаас гарах вэ гэдэг ийм асуудал байгаад байдаг гээд. Тэгсэн чинь одоо бидний авсан мэдээллээр аль хэдийн та нар хяналтаа тавих болов уу л гээд бидэнд 220 сая доллар өгчихсөн юм байна гэж. Тэгэхээр тэрийгээ аваад бид хэрэглээд хяналтаа тавиад явах бүрэн боломжтой байгаа юу л гэж ингэж асууж байгаа юм.

Нөгөө бас асуулт байна. Тэр нь юу гэхээр зэрэг бид бас ингээд үзэхээр зэрэг “Оюутолгой”, юуны чинь “Рио Тинто”-гийн хувьцаа эзэмшихэд эзэмших дотор, нэмээд 1 минут авчих уу?

О.Батнайрамдал: Зулпхар гишүүнд нэмээд 1 минут.

С.Зулпхар: Оюутолгойгийн тэр хувьцаа эзэмшигч дотор бол бидний бас судалж мэддэг олон улсын том санхүүгийн корпорацууд байгаад байгаа байхгүй юу. Та бүхэн бас би нэрийг нь хэлээд яах вэ угаасаа харагдаж байгаа учраас. Тэгэхээр “Рио Тинто” одоо тэр авсан зээлээ энэ чинь зээл аваад бид тэр зээлийн хүүг төлөөд байгаа шүү дээ. Тэр санхүүгийн корпорацуудаас авсан, авсан байна уу эсвэл өөр газраас авсан уу энийг бас зүгээр танин мэдэхүйн талаас нь гэдэг юм уу зүгээр сонирхож асууж байгаа шүү зориуд.

Өөрөөр хэлбэл, өөр өөрөөсөө зээл авчихсан байдал байгаа юм биш биз дээ гэдэг зүгээр ийм л ойлголт байгаа юм. Би зүгээр үзсэн л дээ бүгдийг нь. Тэр битгий хэл жишээ нь “Рио Тинто” чинь 1880 хэдэн оноос эхлээд л бол маш тодорхой айлын бараг 100 хувийн эзэмшил гэж ярьдаг л байсан ийм л компани байгаад байгаа. Сүүлд бол энэ чинь санхүүгийн корпорацууд ороод ирчихсэн байгаа байхгүй юу. Тэгэхлээр тэндээсээ зээл аваад явчихсан байна уу? Зүгээр энийг сонирхож байгаа шүү.

О.Батнайрамдал: Зупхар гишүүний асуултад хариулъя. Тодорхой хариулъя. 4 номерын микрофон.

Э.Ганхүү: “Рио Тинто” компани маань анх далд уурхайн бүтээн байгуулалтын 4.1 сая долларыг арилжааны 15 банкнаас авчихсан байсан. Авсан байсан зээлийг “Рио Тинто” өөртөө шилжүүлж аваад яг энэ далд уурхайн бүтээн байгуулалтад зарцуулсан байгаа. Яг энэ 4.1 тэрбум доллар яг 15 банкнаас “Рио Тинто”-гийн эх үүсвэр орсон байна уу үгүй байна уу гэдэг дээр санхүүжилт гэдэг талд нь “Эрнст энд Ян” компани аудит хийгээд хийгээд 100 хувь энэ арилжааны банкнуудын санхүүжилт орсон байна гэсэн дүгнэлтээ гаргасан байсан. Бид бүхэн энэ орсон мөнгийг буцаагаад яг далд уурхайн зардалд зарцуулж уу үгүй юу гэдэг дээр нь аудит хийлгэхээр шаардлага хүргүүлсэн байгаа. Энэ шаардлагын дагуу “Рио Тинто” Монголын талаас тэгвэл яг ямар ямар зардал дээр гүйцэтгэлд аудит хийлгэх ажлын даалгавраа хүргүүл гэсэн. Тэрнийх нь дагуу энэ өнгөрсөн 4 сард хүргүүлсэн байгаа. Манай яг “Эрдэнэс Оюутолгой” компанийн хувьд гэх юм бол яг аудитын зардалд гаргах санхүүжилт нь байхгүй. Түрүүний энэ 20 сая гэж байгаа доллароос 18 сая доллар авсан байна. 22 оноос 23, 20.../минут дуусав./

О.Батнайрамдал: 4 номерт нэмэлт 1 минут өгчихье. Хариултаа товчхон яг точный хариул.

Э.Ганхүү: “Оюутолгой” компаниас авсан байгаа гээд 18.2 сая доллар бол 21, 22, 23 онуудад, 24 онуудад авсан санхүүжилтүүд байгаа.

О.Батнайрамдал: Дамдинням сайд бас ороод ирлээ бас нэмэлтээр асуучихъя.

Тэгэхээр гишүүд ээ та бас өөрөө ажлын хэсгээ ахалж орсон учраас нэгдүгээрт тэр хэлэлцээрийнхээ бас олон нийтэд тавьсан мэдээллийн хүрээнд бас хэлэлцээр ямархуу яваа? Хоёрдугаарт яг үнэнийг хэлэхэд Хянан шалгах түр хороон дээр энэ гишүүдийн бас олон сар яриад байсан зүйл нь зүгээр ийм хэлэлцээрт орох боломж байна аа, хуулийн хугацаа байна, гэрээний хугацаа байна. Энэ хугацаандаа багтаад хэлэлцээрт орооч л гэж бид нар яриад байсан шүү дээ. Тэгэхээр ингээд зохион байгуулалтад ороод хэлэлцээрт орж байгаа нь, хэлэлцээрт ороод эхний үр дүн гараад эхэлж байгаа нь сайшаалтай гэж харж байгаа.

Миний асуулт энэ. Протокол олон нийтэд тавигдсан гэж харсан тээ? Тэн дээр гол асуудал байгаа шүү дээ. Гэрээн дээр 1 сарын 30 гээд хөрвүүлэх хугацаа чинь дуусах гээд байна тэр. Тэр дуусгахад хэрвээ бид нар нөгөө тал хугацаа дуусчихсан гэж хэлэхэд бид нарт хариулт байхгүй байхгүй юу. Тэгэхээр энэ хугацаанд тэр протоколын 1 дээр бол сунгахаар тохиролцсон гэж байна л даа. Энийг яг юу гэж ойлгох юм? Энэ 1 сарын 30 хүртэл эрмэлзэнэ гэж байгаа юм. Тэгээд 1 сарын 30-даа амжихгүй бол цаашаагаа үргэлжлэх энэ орон зай нь нээгдсэн гэж ойлгож болох уу? Энийг яг албан ёсоор гишүүдэд бас тайлбарлаж өгмөөр байна.

5 номер.

Г.Дамдинням: Гишүүддээ оройн мэнд хүргэе. Би бас энэ бас Ерөнхий сайдаар танилцуулгатай байсан учраас жоохон хоцроод ирлээ. Уучлал хүсье. Ажлын хэсгийн, Түр хорооны ахлагчийн асуултад хариулъя.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 67, 68, 73 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгүүд нэгдсэн төлөвлөгөөгөө баталж, Засгийн газраар удирдамжаа батлуулаад энэ удирдамжийнхаа дагуу бид нар хэлэлцээрт ороод ингээд явж байна. Таны яг тодорхойлон асуусан тэр “Рио Тинто” талаас ирсэн 10 хүн бол гэрээний асуудлаар бүрэн хэмжээнд хэлэлцээр хийх эрхтэй хүмүүс ирсэн. Монгол Улсын талаас бол Жавхлан сайд бид хоёр ахлаад бас бүрэн эрхтэй ийм гишүүд 2 талаасаа уулзаад тэгээд тэр протокол гээд байгаа зүйл бас их тийм амархан гарчхаагүй. Бүтэн өдрийн турш бид нар ярилцаж байгаад тэгээд 2007 онд үндсэндээ 1 удаа 7 жилийн түгжээ нь онгойсон байх үед манай манай Монгол Улсын талаас ямар үйлдэл хийж чадалгүй боломжоо алдсан. 18 онд, уучлаарай 18 онд. Одоо 25 онд бид нар энэ боломжоо алдахгүй ээ, нэг. Хэлэлцээр бол урт удаан хугацаанд үргэлжилж магадгүй байгаа учраас бид 2026 оны 1 дүгээр сарын 31-нээс өмнө хэлэлцээрээ, энэ хэлэлцээрийг эхэлсэн гэж нэгдүгээрт үзнэ ээ. “Рио Тинто”-гийн тал тэрийг зөвшөөрнө.

Хоёрдугаарт, гэрээн дээр дурдагдсан байгаа 2026 оны 1 дүгээр сарын 31-нээс өмнө хэлэлцээрээ хийж дуусгана аа. Хэрэв ямар байдлаар зөвшилцөлд хүрэхгүй бол 2021 оны, 26 оны 1 дүгээр сарын 31 гэдэг өдрийг бид тооцохгүйгээр гэрээгээ үргэлжлүүлээд эцэст нь үр дүн гартал нь хэлэлцээрээ хийж явуулна гэдэг. Өөрөөр хэлбэл 7 жилийн түгжээг мулталж авсан гэдгээ талууд зөвшөөрч гарын үсэг зурсан. Тэгэхээр тэр 7 жилийн түгжээ бол байхгүй гэж ойлгох хэрэгтэй. Тийм.

О.Батнайрамдал: Дамдинням сайд бас нэмээд юм асуугаадахъя. Тэгэхээр энэ дээр чинь бас “Онтрэ”-гийн асуудал байгаа. Хянан шалгах түр хорооны хүрээнд ч гэсэн хувь нийлүүлэгчийн зээлийн хүү болон “Онтрэ” гэсэн 2 үндсэн сэдэв дээр байгаа. Бидний ойлгож байгаагаар “Рио Тинто”-гоос ирсэн захиа дээр хоёулаа энэ хоёр асуудал хоёулаа дурдагдсан гэж ойлгож байгаа тээ? Тэгэхээр протокол дээр “Онтрэ” ерөөсөө дурдагдаагүй байна. Тэгэхээр энийг та бас нэмж тайлбарлах хэрэгтэй байна. Яагаад “Онтрэ” дурдагдаагүй билээ? “Онтрэ” ер нь хэлцэл дотор бас явж байгаа юу?

Г.Дамдинням: “Онтрэ”-той холбоотой асуудал дээр бол бид өмнө нь Түр хороон дээрээ бас байр сууриа илэрхийлж байсан. “Рио Тинто”-той хийж байгаа хэлэлцээр дээр “Онтрэ”-тэй холбоотой асуудал дурдагдаж яригдаж байгаа юу гэвэл яригдаж байгаа. Гэхдээ “Онтрэ” гэж компани тусдаа аж ахуйн нэгж, хуулийн этгээд учраас “Онтрэ”-тэй хэлэлцээр бас эхэлж байна. Яг одоо эхлээд явж байна. Би бол ажлын хэсгийн ахлагчийн хувьд “Онтрэ” ХК, “Онтрэ” компанийн ТУЗ, мөн бас гүйцэтгэх захирлыг хэлэлцээрт ир гээд дуудчихсан байгаа. Монгол Улсад ирсэн мэдээтэй байна. Манай байр суурь бол “Оюутолгой”, “Рио Тинто” компанийн хувьд энэ асуудалд оролцох эрх үгүй. Яагаад гэвэл Монгол Улс оролцоогүй байгаа. Бид хэнд ч тийм зөвшөөрөл өгөөгүй байгаа учраас бид тэр эзэмшиж байгаа эзэнтэй нь ярина. Тэрнийхээ дараа бусад холбогдох этгээдүүдтэй шаардлагатай бол хэлэлцээрт орж болно гэсэн зарчмын байр суурьтай байгаа.

О.Батнайрамдал: Тэгэхээр “Онтрэ” ямар ч байсан хэлэлцээр бас давхар явж байгаа гэж ойлголоо. Тэгээд хоёулаа л бас паралельный явах нь зүй ёсны хэрэг. Хоёулан дээр нь л Монгол Улсын хамгийн гол нь эрх ашиг хангагдсан ийм шийдэл гарахыг л бид нар зөвхөн Хянан шалгах түр хорооны гишүүдээс гадна Монголчууд бүгдээрээ хүлээж байгаа шүү. Тэгэхээр энэхүү хэлэлцээрээ бас цаг хугацаанд нь багтааж амжилттай Монгол Улсын эрх ашгийг хангасан хэлцэл хийж явахыг хүсье.

Тэгээд одоо Хянан шалгах түр хорооны хувьд ч гэсэн бас Дамдинням сайд сууж байгаа учраас бас хэлье. Бид нар Хянан шалгах түр хороо Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өгөгдсөн чиглэлийнхээ дагуу, хуулийн дагуу бид нар сонсголоо зохион байгуулж, нэгдсэн тайлангаа Улсын Их Хурлаар оруулж батлуулна. Бид нар хянан шалгах шинжээчид 60 гаруй давсан мянган хуудас баримт бичиг дээр ажиллаж байгаа. Оюутолгойгоос харамсалтай нь ирсэн бүх баримт бичгүүд байгууллагын нууцад дарсан. Хуулиараа ч гэсэн байгууллагын нууцыг гаргах эрх нь тухайн байгууллагад л байгаа. Хэрвээ Оюутолгой тэр байгууллагын нууцаасаа хэрвээ жишээлбэл гаргахаас татгалзсан бол бид нар ашиглах боломжгүй ийм байдалтай нэгдүгээрт.

Хоёрдугаарт бас Оюутолгойтой холбоотой Засгийн газрын янз бүрийн ажлын хэсгийн тайлангууд холбоотой бичгүүд бас төрийн болон албаны нууцын хуулиар 2 өөр хуулиар зохицуулагдаж байгаа шүү. Төрийн болон албаны нууцын тухай хуулиар зохицуулагдаж, нэг ёсондоо Засгийн газраас бас нууцад бүүр заримыг нь маш нууцад авсан байгаа юм. Тэгэхээр зарим нь бүүр жишээлбэл төрийн нууцад авсан бол энэ 10 жилийн хугацаатай байдаг. 10 жил нь дуусчихсан хүртэл баримт бичгүүд тэр дотор нь явж байгаа юм. Нэг ёсондоо хуулийн хугацаа нь дуусчихсан. Гэхдээ Засгийн газар тэн дээр хөдөлж шийдэл гаргахгүй болохоор бид нар хуулийн хугацаа нь дуусчихсан гээд ашиглах ч хэцүү, үгүй ч хэцүү иймэрхүү асуудлууд байгаад байна.

Тэгэхээр Түр хорооны сонсгол явахад ард түмний тэр мэдэх эрхээр хангахад буцаад Түр хорооны сонсгол үр дүнтэй явахад Засгийн газраас тэр холбогдох баримт бичгүүд бидний хүрээ хязгаарт орж байгаа баримт бичгүүдийг нууцаас гарах дээр анхаараад өгөөч гэж бас Дамдинням сайдаас хичээнгүйлэн хүсмээр байна. Энэ нь буцаад бид нар Оюутолгой дээр илүү илүү мэдэх эрхээр нь хангасан илүү олон баримтыг гаргаж ирж олон нийтэд тайлагнасан энэ мэдэх эрхээр нь хангах боломж нөхцөл нь бүрдэх юм. Тэгэхээр та энэ дээр бас анхаараад өгөөсэй гэж хүсэж байна.

Бидний ойлгож байгаагаар ч гэсэн Занданшатар Ерөнхий сайд ч гэсэн хэлсэн. Илүү ил тод байдал дээрээ бас анхаарч байгаа. Тэгэхээр Оюутолгойтой холбоотой мэдээллүүд дээр ил бас илүү нэмэлт мэдээллүүд урьд өмнөх, бараг зарим нь 10 хэдэн жилийн өмнөх ажлын тайлангууд ч гэсэн бид нарт хэрэгтэй байгаа. Тэгэхээр тэр тайлангуудыг, ажлын хэсгийн тайлангуудыг холбогдох баримтуудыг Засгийн газар нууцаас бас бодлогынхоо хүрээнд гаргаж өгөөч гэж бас чин сэтгэлээсээ танаас бас хүсье.

Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. Өөр нэмэлтээр орох гишүүд байна уу?

Жаргалан гишүүнийг нэмье, Болормаа гишүүнийг бас нэмье. Өөр? Болормаа гишүүнээр нэмээд тасалчихъя. Жаргалан гишүүний микрофоныг өгье.

Б.Жаргалан: Засгийн газраас байгуулагдсан ажлын хэсэг “Рио Тинто” групп хоорондын хэлэлцээний протоколтой танилцсан. Хэлэлцээний протоколд тодорхой 4 асуудал тусгагдсан байгаад байгаа. Тэгээд нэгдүгээр асуудлын хүрээнд болохлоор зээлийн хүүтэй холбоотой асуудлын тэр цаг хугацааны түгжээг тайлдаг, дээр хийгдсэн хэлэлцээр бас амжилттай явсан гэж ойлгож байна. Тэгээд энэ бас сайн шийдэл болжээ.

Хоёрдугаарт нь болохлоор энэ зээлийн хүү болон менежментийн төлбөртэй холбоотой 2 асуудал дээр аль алин дээр нь болохлоор олон улсын жишиг, олон улсын стандарт гэсэн үгнүүд орчихсон байгаад байна л даа. Тэгэхээр яах вэ энэ дээр ганц санаа л хэлэх гэсэн юм. Манай талаас мэдээж хэрэг зээлийн хүүг бууруулах, дээрээс нь менежментийн төлбөрийг бас бууруулах энэ тэр эрмэлзлүүд тавьж байгааг нь ойлгож байгаа. Гэхдээ асуудлаа томъёолохдоо ер нь Монголын талын өгөөж ямар байх вэ гэдэг агуулгаар нь томъёолбол мэдээж хэрэг олон улсын жишгүүдийг нь тооцох нь зүй ёсны хэрэг байх.

Гэхдээ ер нь анхнаасаа Оюутолгойн хэлэлцээр бүүр анх эхлэхдээ ч гэсэндээ Монголын талын өгөөж хэд байх вэ гэдэг дээр бас нэлээн ул суурьтай ярианууд болж байсан. Тэгэхээр яг энэ Монголын талын өгөөж дээрээс бас суурилсан Монголын талынхаа өгөөжийг нэмэгдүүлэх энэ гэрээний үлдсэн хугацаанд Монголын тал жил болгон ямар өгөөж яаж хүртэх вэ тэр тэр өнцгөөс нь бас томъёоллуудаа бас хийж явах нь зөв болов уу гэсэн ийм санаа л хэлэх гэсэн юм. Баярлалаа.

О.Батнайрамдал: Жаргалан гишүүн санал хэллээ тээ? Тэгэхээр Жаргалан гишүүний санал аягүй чухал санал ярьж байна шүү. Та, Жавхлан сайд та 2 ч гэсэн бас үгэндээ хэлж байсан гэж ойлгож байгаа. Анх тэр Жаргалан гишүүний хэлж байгаагаар 2010 онд тэр 9, 10 онд чинь Монголын талын өгөөж 53 хувь гэж тухайн үедээ бүүр протокол дээр байдаг шүү дээ. ТЭЗҮ дээр нь орж байсан. Тэгэхээр яг тэр санаа цаашаагаа үргэлжлэх ёстой шүү гэсэн саналтай 100 хувь нэгдэж байна. Яах вэ санал байлаа. Гэхдээ Дамдинням сайд нэмэлт тодруулга өгөх үү? 5 номер.

Г.Дамдинням: Тийм, Жаргалан гишүүн их чухал санал хэлж байна. Ажлын хэсгийн ахлагч. Ер нь бид манай Засгийн газраас өгсөн бид нарт өгсөн чиглэл дотор яг байгаа. Бид яг энэ асуудлаараа л томъёолж явж байгаа. Тэр маань бас дэлгэрэнгүй бид нар ярьж чадахгүй байна. Яагаад гэвэл нууцаар батлагдсан учраас.

Хоёрдугаарт, энэ 2 дугаар point болон 3 дугаар point хэсэг дээр энэ нөгөө зээлийн хүү, хувь нийлүүлэгчийн зээлийн хүү. Хоёрдугаарт менежментийн үйлчилгээний төлбөрүүдийг бид ярилцана. Бууруулна гэдгийг нь зөвшөөрүүлээд гарын үсэг зуруулчихаж байгаа юм. Тэгээд цаашаа бол бид нар яг тэр нөгөө зорилго руугаа хүрэх хэмжээнд л шахаж байгаа гэсэн үг. Тийм санал нэг байгаа. Яг тэр чиглэлд ажиллаж байгаа тийм.

О.Батнайрамдал: Болормаа гишүүн. Болормаа гишүүний микрофоныг өгье.

Э.Болормаа: Хэлэлцээр хийж байгаа ажлын хэсгийнхэн болон ахалж байгаа хүмүүстээ амжилт хүсье. Ямар ч байсан бага ч гэсэн бид нар урагшлаад явж байна гэдэг сайшаалтай зүйл. Өнгөрсөн 5 дахь өдөр энэ асуудлыг бас Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцсэн. Түүнээс хойш бас энэ хэлэлцээрийн талаар Засгийн газрын сайд нар мэдээлэл өгөхдөө Хянан шалгах түр хороог магадгүй попроод байна гэдэг энэ зүйлийг хэлээд байгаа юм. Би энэ дээр аягүй шүүмжлэлтэй хандаж байгаа юм.

Тэгээд энэ сонсголоор энэ бүхэн ил болоод яриасай гэж бодож байгаа юм. 7 жил тутам бид 1 удаа хүүгээ буулгах боломжтой, хэлэлцээрт орох боломжтой. 2025 онд энэ боломжоо ашиглаач гээд энэ Хянан шалгах түр хороо бий болоод харин энийг ил тод гаргаж шахаж шаардсаны үр дүнд энэ яригдаж байна. Магадгүй энийг ил гаргаад шахаж шаардаагүй бол яг өмнөх шигээ ингээд л чимээгүй өнгөрөх

байсан. Тэгвэл 2018 онд энэ хэлэлцээрийг хийгээгүй хүмүүстээ тэгвэл бид ямар хариуцлага тооцох юм бэ? Энэ эс үйлдэхүйгээс болж ямар хэмжээний зардал Монгол Улсын талд ингэж нэмэгдэж гарч ирсэн бэ гэдгийг бас тэгвэл адилхан бид ярих нь л зүйтэй шүү дээ.

Одоо ингээд гэнэн цагаан сайхан тагтаа нар шиг, цагаан тагтаа нар шиг гарч ирээд л энд хүмүүс ажил ярьсан чинь та нар бараг попорлоо бид нар угаасаа энийг хийж байсан юм гээд. Энийг ярьж байгаа Ерөнхий сайд өөрөө тухайн үед Хэрэг эрхлэх газрын дарга байсан. Энийг ярьж байгаа Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга өөрөө тухайн үед сайд нар байсан. Тэгээд яагаад энэ хүмүүс тэр үедээ хийгээгүй ажлаа өнөөдөр бидний хэсэг залуучууд гарч ирээд энийгээ хийгээч гэж шахсан чинь та нар попорч ориллоо бид нар угаасаа энийг хийж байгаа шүү дээ гэдэг ийм хандлага гаргаад байгаа юм бэ? Ийм хариуцлагатай, хариуцлагагүй мэдэгдлүүд хийж болохгүй шүү дээ. Энийг Хянан шалгах түр хорооны дарга анхаарч авч энэ албан ёсны байр сууриудыг илэрхийлэх ёстой. Хянан Шалгах түр хороон дээр энэ түүхэн асуудлуудыг ч гэсэн хөндөх ёстой. Энэ дээр хариуцлагын асуудал ч гэсэн яригдах ёстой гэж би хувьдаа бодоод байгаа юм. Хэн хэвлэлээр илүү чанга дуугарсан ч юм уу, хэн мэдээллээ илүү сайн түгээж байгаагаасаа ингэж үнэн мөн нь тодорхойлогдохгүй шүү дээ. Монголын ард түмэн бүгдээрээ мэдэж байгаа. Хэн тухайн үед сайд дарга нар байж байгаад энэ дээр эс үйлдэхүй үйлдсэнээс болж өнөөдөр бид ийм хэмжээний өндөр зээлийн хүү төлөөд явж байгаа вэ гэдгийг бүгдээрээ мэдэж байгаа байх гэдгийг хэлье.

Тэгэхээр энэ ажлын хэсэгт ажиллаж байгаа албан тушаалтнууд ч гэсэн үүнтэй адилхан 7 жилийн дараа хүмүүс суугаад ингээд ажил хийсэнгүй гэж эс үйлдэхүй хийхгүйн тулд яг бодитой үр дүн гаргахын төлөө анхаарч ажиллана гэдэгт итгэлтэй байна.

О.Батнайрамдал: Болормаа гишүүн үг хэллээ.

Тэгэхээр бас энэ завшааныг ашиглаад энэ Хянан шалгах түр хорооны 11 гишүүндээ бас баярлалаа гэж хэлмээр байгаа юм. Бид нар 4 сар Хянан шалгах түр хороо эхэлснээс хойш 4 сар болж байна. Анх эхлэхдээ л бид нар ер нь байгуулсан үндсэн шалтгаан бол энэ хэлэлцээр эхлэх ёстой, энэ дээр Монгол Улсын эрх ашиг хангагдах ёстой л гэж бид нар хэлсэн юм. Ер нь энэ сэдэв дээр бид нар хэрвээ ажил явж байсан бол Хянан шалгах түр хороо байгуулах шаардлага ч үгүй байсан.

Тэгээд ямар ч байсан 4 сарын хугацаанд хэлэлцээрийн ширээн дээр суухад яг энэ энд сууж байгаа Хянан шалгах түр хорооны гишүүд маань бас нэлээн чанга дуугарч, Түр хороог Байнгын хороо шиг долоо хоног болгон хуралдтал хуралдаж байгаад ямар ч байсан хэлэлцээрийн ширээ дээр суулгасан шүү. Тэгэхээр энэ Түр хорооны гишүүддээ энэ завшааныг ашиглаад бас баярлалаа гэж хэлмээр байгаа юм. Энэ хамгийн гол нь амжилттай бас үргэлжлэх ёстой.

Тэгээд Жавхлан сайд, Дамдинням сайд 2 ямар ч байсан Ерөнхий сайдын захирамжаар гарсан ажлын хэсгүүд эхний хэлэлцээр дээрээ ингээд протокол дээр бас албажуулаад авдаг нь бас зөв. Хугацаа, хамгийн гол нь том асуудал болж байсан тэр хугацаа бас цаашаагаа үргэлжлэхээр болж байгаа гэдэг дээр талархалтай хандаж байгаа. Энэ эрчээрээ явах ёстой. Монгол Улсын эрх ашиг хангагдтал бид нар Хянан шалгах түр хороо дуугарсаар байх болно. Зарим хүмүүс

хэтэрхий попроод гэж ярьж л байна лээ. Юу ч гэж хэлсэн хамаагүй Монгол Улсын эрх ашиг нэгдүгээрт хангагдах л ёстой.

Тэгээд удахгүй 12 сарын эхээр Хянан шалгах түр хорооны сонсгол эхэлнэ. Тэгэхээр Болормаа гишүүний хэлж байгаа асуудлууд Хянан шалгах түр хорооны сонсгол ер нь өнгөрсөн цаг хугацаанд бид нар энэ зээлийн хүүг бууруулах, энэ “Онтрэ”-гийн асуудалтай холбоотой хүрээ хязгаарын хүрээнд бид нар хяналт шалгалт хийж байгаа учраас бүх асуудлууд гарч ирнэ. Дараагийн долоо хоногоос өгсүүлээд гэрчийн нэрс зарлагдаж эхэлнэ. Ингээд бид нар Хянан шалгах түр хорооны үндсэн ажил дараагийн долоо хоногоос эхлээд эхэлж байгаа юм.

Тэгээд ажлын хэсэгт амжилт хүсье. Тэгээд цаашаагаа энэ эрчээрээ үргэлжлэх ёстой. Энэ дээр хамгийн гол нь Монгол Улсын эрх ашиг бас хангагдсан ийм үр дүн заавал бас гарах ёстой байгаа шүү. Тэгээд энэ дээр Засгийн газар, Улсын Их Хурал бид нар Монгол Улсын эрх ашгийн төлөө бид нар нэг талдаа зогсоно. Энийг олон дахин хэлж байгаа юм. Тэгэхээр энэ Монгол Улсын эрх ашгийн төлөө бид нар нэг талдаа ямар ч тохиолдол байсаар байх болно. Ингэж байгаа Монгол Улсын эрх ашиг хангагдсан ийм үр дүнд бид бид нар хүрэхийн тулд бүх арга хэмжээг Хянан шалгаж түр хороо хууль эрхийнхээ хүрээнд авна.

Ерөнхий сайдын захирамжаар байгуулагдсан 67, 83 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн хүрээнд мэдээлэл сонслоо.

Ажлын хэсгийнхэнд баярлалаа.

Өнөөдрийн хуралдааны товд зургаад нь хамгийн сүүлд нь “Оюутолгой” компанийн ТУЗ-ийн дарга, гишүүд, гүйцэтгэх удирдлага ирэх ёстой байсан. Өчигдөр бас и-мэйлээр ирэх боломжгүй гэдгээ мэдэгдсэн байна лээ. Ингэж явсаар байгаад бүгдээрээ угаасаа сонсгол руугаа ингээд орох юм байна. Гэхдээ шалтгаан нь урьд өмнө нь нэг захиа ирэхдээ биднийг Оюутолгойн уурхай дээр ирж, биечлэн ирж уулзалт хийгээч гэсэн байна лээ. Хүсэлт ирсэн.

Гэхдээ энэ Оюутолгой бид нар урьсан, уриагүйгээр бид нарын төлөвлөгөөнд угаасаа байгаа зүйл. Тэгэхээр бид нар Оюутолгой дээр хуваарийнхаа хүрээнд ажлын төлөвлөгөөнийхөө дагуу очдогоороо очно. Гэхдээ үүгээр Монгол Улсын парламент дээр Оюутолгой ирж танилцуулгаа тавих асуудлыг аргалж өнгөрнө гэж юм байхгүй ээ. Бид нар хурал дээрээ дараа дараагийн хурал дээрээ Оюутолгойг бид нар дуудсаар байх болно. Энэ зарчим шүү дээ. Ганцхан “Оюутолгой” компани гэж байгаа юм биш. Монгол Улсын парламент дээр дуудагдсан, ялангуяа тэр дундаа төрийн эзэмшилтэй аж ахуйн нэгжүүд болон төрийн байгууллагууд бүгдээрээ л ирдэг.

Тэгэхээр энэ жишгийг “Оюутолгой” компани ганцаараа хангахгүй үлдэнэ гэж юм байхгүй ээ. Тэгээд удахгүй бид нар сонсгол руугаа орсон ч гэсэн Оюутолгойтой холбоотой олон хүн нэрсээр дуудагдаж сонсгол дээр ирэх шаардлагатай болно. Харин сонсгол дээр элдэв янзын тайлбар өгч ирэхгүй байх ийм зүйл бас гаргаж болохгүй шүү гэдгийг бас албан ёсоор хэлье гэж бодож байгаа. Тийм учраас “Оюутолгой” компани уул нь ирэх ёстой байсан. Ирээгүй учраас дараагийн ирэх хүртэл нь дахиад энэ асуудлыг хойшлууллаа.

Өнөөдрийн Хянан шалгах түр хорооны хуралдаан энэ хүрээд хаасныг бас мэдэгдье.

16.25 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР